

ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН  
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/47

Сүмбэр сум

Өндөржүүлсэн бэлэн байдлын үед хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эргүүл хийх үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5, 18.1.6, 18.2.1 дүгээр зүйл, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.4 дүгээр зүйл, Засгийн газрын 2019 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан Онцгой байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэх журам, Монгол Улсын шадар сайдын 2021 оны 57 дугаар тушаал, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2021 оны А/10 дугаар тушаалаар батлагдсан Коронавируст халдвар /ковид-19/ цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 5.3, 7.4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед хүүхдүүдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гудамж талбай болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийн гэрээр эргүүл хийх үйл ажиллагааны удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах төсвийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2. Үйл ажиллагааг зохион байгуулж үр дүнг тайлагнан ажиллахыг Хүүхдийн эрхийн Улсын байцаагч (Б.Шархүү)-д үүрэг болгосугай.


3. Үйл ажиллагаанд зарцуулагдах 435 390 (дөрвөн зуун гучин таван мянга гурван зуун ер) төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг нягтлан бодогч (Д.Оюунцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ОЮУНБИЛЭГ

ГБХЗХгазрын даргын 2021 оны  
06 сарын 07-ны өдрийн  
дугаар тушаалын /...-р хавсралт



**ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН БАЙДЛЫН ҮЕД ХҮҮХДҮҮДИЙГ  
БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,  
ГУДАМЖ ТАЛБАЙ БОЛОН ЭРСДЭЛТ НӨХЦӨЛД  
БАЙГАА ХҮҮХДҮҮДИЙН ГЭРЭЭР ЭРГҮҮЛ ХИЙХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ.**

**НЭГ. Үндэслэл**

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5, 18.1.6, 18.2.1 дүгээр зүйл, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.4 дүгээр зүйл, Засгийн газрын 2019 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан Онцгой байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэх журам, Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/10 дугаар тушаалаар батлагдсан Коронавируст халдвар /ковид-19/ цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 5.3, 7.4 дүгээр зүйлүүдийн хэрэгжилтийг хангах.

**ХОЁР. Зорилго**

Аймаг орон нутгийн хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын үед хүүхдийн эрх, хамгаалал, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн асран хамгааллын асуудал, олон нийтэд хүүхдийн эрх, хамгааллын хууль эрх зүйн мэдээллийг хүргэх.

**ГУРАВ. Хугацаа**

2021-06-07-ээс 2021-07-09

**ДӨРӨВ. Хамрах хүрээ**

Говьсүмбэр аймаг болон Налайх дүүрэг

**ТАВ. Хамтран ажиллах байгууллага**

Сумдын хамтарсан баг, Булган аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар

**ЗУРГАА. Зохион байгуулалт**

Албан хаагчид эргүүлийн хуваарьт заасан хугацаанд “Эрсдэлийн түвшин тогтоох программ”-д бүртгэлтэй хүүхдүүд болон “Хүүхдийн эрх, хамгааллын судалгаа”-д суурилан тухайн сумын гудамж талбай, болон эрсдэл өндөр бүхий хүүхдүүдийн гэрийн орчим тандалт, ажиглалт хийнэ. Шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагын дэмжлэгийг авч /цагдаагийн албан хаагч/ “Хүүхдийн эрсдэлийн үнэлгээ”-г хийж холбогдох байгууллага, үйлчилгээнд хамруулан ажиллана.

Эргүүлд гарч байгаа албан хаагчид тусгайлан бэлтгэсэн “Эргүүлийн тэмдэглэл хөтлөх дэвтэр”-т тухайн өдрийн эргүүлийн тэмдэглэлийг хөтөлж дараагийн эргүүл хийх албан хаагчдад шилжүүлнэ.

Налайх дүүргийн 4 дүгээр зөрлөг гэх газар Говьсүмбэр аймгийн иргэн Б.Ү-тэй уулзаж хүүхэд үрчлэлтийн талаарх мэдээллийг авна.


**ДОЛОО.** Гарах үр дүн

- Өндөржүүлсэн бэлэн байдлын үед орон нутгийн өндөр эрсдэл бүхий хүүхдүүд гэртээ хэрхэн, аж төрж байгааг ажиглалтын судалгааны аргаар олж илрүүлэх.
- Эрх нь зөрчигдөж хамгааллын үйлчилгээ шаардлагатай байгаа тухайн өрхийн гишүүнд цаг алдалгүй “Хариу үйлчилгээ” үзүүлнэ.
- Өндөр эрсдэл бүхий хүүхдүүдийн гэр бүлийн гишүүд хүүхдийн эрх, хамгааллын тухай хуулийн мэдээлэлтэй болно.

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:  
ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН  
ХҮҮХДИЙН ЭРХИЙН УЛСЫН БАЙЦААГЧ *Б.ШАРХҮҮ* Б.ШАРХҮҮ

228

ГБХЗХгазрын даргын 2021 оны  
06 сарын 07-ны өдрийн  
дугаар тушаалын 2-р хавсралт



ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН БАЙДЛЫН ҮЕД ХҮҮХДҮҮДИЙГ  
БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЖ,  
ГУДАМЖ ТАЛБАЙ БОЛОН ЭРСДЭЛТ НӨХЦӨЛД  
БАЙГАА ХҮҮХДҮҮДИЙН ГЭРЭЭР ЭРГҮҮЛ ХИЙХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ

| №               | Материалын нэр      | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ      |
|-----------------|---------------------|-------------|------------|----------------|---------------|
| 1               | Шатахуун            | литр        | 189        | 1'510          | 285390        |
| 2               | Маск                | ш           | 100        | 200            | 20'000        |
| 3               | Нэг удаагийн бээлий | хайрцаг     | 1          | 30'000         | 30'000        |
| 4               | Санитал/Том/        | ш           | 8          | 12500          | 100000        |
| <b>Нийт үнэ</b> |                     |             |            |                | <b>435390</b> |

ТӨСӨВ БОЛОВСРУУЛСАН:  
ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН  
ХҮҮХДИЙН ЭРХИЙН УЛСЫН БАЙЦААГЧ *А.Шархүү* Б.ШАРХҮҮ